



Мөнхбаяр, 2003

## Хархорум хотоос олдсон нангиад бичээстэй тамга



Монгол-Германы хамтарсан 'Хархорум' хээрийн судалгааны багийн 2001 оны судалгааны хотын төв хэсэгт малтсан худалдаа, гар үйлдвэрлэлийн малтлагаас нэгэн хүрэл тамга олдсон.

Уг тамга дөрвөлжин ултай, орой руугаа шувтан хэлбэрийн гонзгой бариултай, 730 грамм жинтэй. Тамганы ул хэсэг 6,2 см урт, 6,2 см өргөн, 1,5 см зузаан тэг дөрвөлжин бөгөөд дөрвөн талруугаа ялимгүй хазайсан байна. Суурийн төв хэсэгт суулгаж цутгасан бариул нь 5,5 см өндөр, сууриараа 3,5 см урт, 1,5 см өргөн, оройн хэсэгтээ 2,9 см урт, 1,2 см өргөн хэмжээтэй бариулын өндөр дээр тамганы өөрийн зузааныг нэмж тооцвол нийтдээ 7,5 см болж байна. Дардас талдаа дөрвөлжин, орой буюу ар талдаа нангиад бичээстэй. Тамганы бичээсийг монголын эрдэмтэн Б. Сумьяабаатар, ХБНГУ-ын Бонны их сургуулийн судлаач Е.Нагел нар тайлан уншсанаа нийтлүүлжээ. Тамганы бичээс нь дээрээс доош бичиж баруунаас зүүнш мөрлүүлсэн байна. Баруун гар талд 1 мөр 5 үсэг, сэнжин дээр 1 мөр 1 үсэг, бариулын зүүн талд 2 мөр 12 үсэг нийт 4 мөр 18 үсэг бий. Эрдэмтэн Б. Сумьяабаатар бичээсийг дараах байдлаар тайлж уншсан байна.

Нэгдүгээр мөр: hu bu zhu shi yin-сангийн яамны эрхэлсэн сайдын тамга

Хоёрдугаар мөр: shang-дээр

Гуравдугаар мөр: xuan guan er nian san yue gi-Аюуширидарын хоёрдугаар оны гурван сарын өдөр

Дөрөвдүгээр мөр: zhong shu zha bu zao-дотоод бичгийн яамны захидал бичгийн хэсэгт үйлдэв хэмээн тайлан уншжээ.

Дотоод бичгийн яамыг Өгөдэй хааны үед Елүй Чу Цай удирдан байгуулжээ. Улмаар Юан улсын үед засаг төрийн хэргийг ерөнхийлөн үүрэгтэй засгийн дээд байгуулга байсан бөгөөд ширээ залгамжлах ханхүү захирдаг байв. дотоод бичгийн яам нь дээд түшмэлийн 5 зөвлөл, төв штабын холбоо, 6 яам /түшмэдийн, сангийн, ёслолын, цэргийн, шүүх, үйлдвэрийн яам/-ыг шууд харьяална. Дотоод бичгийн яаманд монгол бичээч 22, зүүн гарын түшмэл 60, баруун гарын түшмэл 6 байжээ. Нууц бичгийн яам /шу ми юан/ цэрэг дайн зэрэг нарийн харьцааг захирмуй гэжээ. Ийнхүү дотоод бичгийн яам нь дотоод зохион байгуулалт, хэлбэрээ алдалгүй үргэжлэн оршиж Монголын их Юан улс мөхсөний дараа ч Билэгт хааны үеийг багтааж буй Монголын бага хаадын үед дотоод бичгийн яам хэвээр байсаныг тодорхой гэрчлэх археологийн хөдлөшгүй баримт болсон энэхүү тамга нь монголын түүхийн онцгой үнэт олдвор юм. [Мөнхбаяр, 2003, 130-131]